



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/242-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-17
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13-14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14-15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15-17
4. Аудитын тайлан	17-20
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19-20
5. Аудитын илрүүлэлт	21-22
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БУГ	Боловсрол урлагийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.НАРАНГЭРЭЛ ТАНАА

2024.02.25 № САА-2024/242-АА-САА-АДЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн хэсэгт дурдсан зөрчлийг материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд түүний санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд үзүүлэх нөлөөг эс тооцвол Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 19,940.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 15.1.3 дэх заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд БШУЯ-аас 3780,4 мянган төгрөгийн түрээсийн ном, 213,828.8 мянган төгрөгийн цахим анги болон химийн кабинет, сумын хөрөнгө оруулалтаар

62,585.9 мянган төгрөгийн гадна фасадны засварыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Тус сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж, урамшуулалд 27,316.3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 6 зорилтын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 92.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/
			Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	128,382,127.06	238,590,671.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	84,837,860.67	190,085,605.01
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	84,837,860.67	190,085,605.01
31210	Төгрөг	84,837,860.67	190,085,605.01
31211	Төрийн сангийн харилцах	84,837,860.67	190,085,605.01
33	АВЛАГА	975,718.97	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	975,718.97	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	42,568,547.42	48,505,066.82
35100	Түүхий эд материал	3,572,896.00	3,566,283.00
35110	Тусгай зориулалттай материал	3,532,346.00	3,462,983.00
35130	Эм боох материал	40,550.00	103,300.00
35400	Хангамжийн материал	38,995,651.42	44,938,783.82
35410	Бичиг хэргийн материал	0.00	0.00
35420	Аж ахуйн материал	1,184,080.00	433,395.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	8,000.40
35460	Хүнсний материал	563,677.50	2,116,990.00
35470	Бусад хангамжийн материал	37,247,893.92	42,380,398.42
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,225,787,534.23	4,495,257,847.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,225,787,534.23	4,495,257,847.69
39200	Биет хөрөнгө	4,214,390,200.79	4,483,924,514.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,352,100,000.00	4,414,685,944.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-368,558,749.44	-417,953,968.52
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	201,634,448.17	368,104,141.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	-92,169,739.58	-116,876,219.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	165,852,608.87	292,478,445.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	-58,369,779.86	-72,596,211.51
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,997,000.00	7,997,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,398,200.16	-5,997,600.24
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	0.00
39217	Ном	10,302,612.79	14,082,982.79
39300	Биет бус хөрөнгө	11,397,333.44	11,333,333.48
39301	Программ хангамж	2,180,000.00	2,180,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,782,666.56	-1,846,666.52
39303	Бусад биет бус хөрөнгө	11,000,000.00	11,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,354,169,661.29	4,733,848,519.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	19,442,031.24	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,442,031.24	0.00
41300	Өглөг	19,442,031.24	0.00
41360	Бусад өглөг	19,442,031.24	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	19,442,031.24	0.00
51200	Хуримтлагдсан үр дүн	4,323,727,630.05	4,722,848,519.52
51210	Өмнөх үеийн үр дүн	-11,000,000.00	4,323,727,630.05
51220	Тайлант үеийн үр дүн	4,334,727,630.05	399,120,889.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,354,169,661.29	4,733,848,519.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,331,404,658.04	2,832,520,895.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,325,110,993.04	321,611,723.50
120	Нийтлэг татварын бус орлого	4,325,110,993.04	321,611,723.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,334,000.00	2,865,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,746,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,588,000.00	2,865,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,268,491,121.22	282,865,034.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	49,285,871.82	35,881,689.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,006,293,665.00	2,510,909,171.88
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,732,629,800.00	2,196,223,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,732,629,800.00	2,196,223,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	10,940,688.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	10,940,688.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	273,663,865.00	303,745,183.88
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	273,663,865.00	303,745,183.88
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,996,677,027.99	2,402,989,235.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,996,677,027.99	2,402,989,235.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,865,229,706.99	2,277,238,896.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,246,400,275.02	1,579,231,201.05
210101	Үндсэн цалин	957,850,977.26	1,077,964,371.36
210102	Нэмэгдэл	248,650,849.60	450,186,223.76
210104	Урамшуулал	39,898,448.16	51,080,605.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,251,921.34	197,710,510.31
210201	Тэтгэврийн даатгал	106,469,332.75	131,617,410.31
210202	Тэтгэмжийн даатгал	12,521,464.94	16,523,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,032,852.12	13,218,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,369,440.20	3,304,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,858,831.33	33,046,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	224,056,431.24	252,833,852.64
210301	Гэрэл, цахилгаан	14,922,091.50	17,853,907.61
210302	Түлш, халаалт	166,280,910.40	195,372,585.02
210303	Цэвэр, бохир ус	42,853,429.34	39,607,360.01
2105	Нормативт зардал	30,554,930.40	34,777,778.90
210502	Хоол, хүнс	30,554,930.40	34,777,778.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,054,945.00	31,462,340.00
210604	Урсгал засвар	11,054,945.00	31,462,340.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,945,200.00	15,078,943.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,746,000.00	5,514,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,199,200.00	9,564,243.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	179,966,003.99	166,144,270.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,555,041.00	55,514,840.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,517,976.00	20,637,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	96,892,986.99	89,991,530.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,447,321.00	125,750,339.20

2132	Бусад урсгал шилжүүлэг	131,447,321.00	125,750,339.20
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	114,288,321.00	107,894,739.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,159,000.00	17,855,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,334,727,630.05	429,531,659.47
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	30,410,770.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	30,410,770.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	4,334,727,630.05	399,120,889.47

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,013,627,665.00	2,513,774,171.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,334,000.00	13,805,688.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,334,000.00	13,805,688.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,334,000.00	13,805,688.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,746,000.00	11,275,688.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,588,000.00	2,530,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,006,293,665.00	2,499,968,483.88
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,732,629,800.00	2,196,223,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,732,629,800.00	2,196,223,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	273,663,865.00	303,745,183.88
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	273,663,865.00	303,745,183.88
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,874,600,404.33	2,331,929,617.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,874,600,404.33	2,331,929,617.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,740,378,804.33	2,206,248,641.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,246,400,275.02	1,579,231,201.05
210101	Үндсэн цалин	957,850,977.26	1,077,964,371.36
210102	Нэмэгдэл	248,650,849.60	450,186,223.76
210104	Урамшуулал	39,898,448.16	51,080,605.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,227,640.31	196,734,791.34
210201	Тэтгэврийн даатгал	107,445,051.72	130,641,691.34
210202	Тэтгэмжийн даатгал	12,521,464.94	16,523,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,017,252.12	13,218,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,385,040.20	3,304,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,858,831.33	33,046,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	204,614,400.00	272,275,883.88
210301	Гэрэл, цахилгаан	14,922,091.50	17,853,907.61
210302	Түлш, халаалт	166,280,910.40	195,372,585.02
210303	Цэвэр, бохир ус	23,411,398.10	59,049,391.25
2105	Нормативт зардал	30,547,100.00	36,331,091.40
210502	Хоол, хүнс	30,547,100.00	36,331,091.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,844,100.00	31,469,300.00
210604	Урсгал засвар	27,844,100.00	31,469,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,945,200.00	15,078,943.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,746,000.00	5,514,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,199,200.00	9,564,243.27
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,800,089.00	75,127,430.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,049,689.00	54,489,530.40

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,750,400.00	20,637,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	134,221,600.00	125,680,976.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	134,221,600.00	125,680,976.20
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	117,062,600.00	107,825,376.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,159,000.00	17,855,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	139,027,260.67	181,844,554.34
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	54,189,400.00	76,596,810.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,189,400.00	76,596,810.00
2200	Дотоод эх үүсвэрээр	54,189,400.00	76,596,810.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	54,189,400.00	76,596,810.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-54,189,400.00	-76,596,810.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	84,837,860.67	105,247,744.34
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	84,837,860.67
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	84,837,860.67	190,085,605.01

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,000,000.00	0.00	4,323,727,630.05	4,334,727,630.05
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,000,000.00	0.00	4,323,727,630.05	4,334,727,630.05
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,000,000.00	0.00	4,323,727,630.05	4,334,727,630.05
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	399,120,889.47	399,120,889.47
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,000,000.00	0.00	4,722,848,519.52	4,733,848,519.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,606,863,283.88	2,408,526,427.54	198,336,856.34	92.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,606,863,283.88	2,408,526,427.54	198,336,856.34	92.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,149,905,100.00	1,979,100,267.46	170,804,832.54	92.1

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,710,100,300.00	1,579,231,201.05	130,869,098.95	92.3
210101	Үндсэн цалин	1,159,604,700.00	1,077,964,371.36	81,640,328.64	93.0
210102	Нэмэгдэл	483,150,800.00	450,186,223.76	32,964,576.24	93.2
210104	Урамшуулал	67,344,800.00	51,080,605.93	16,264,194.07	75.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	213,762,100.00	196,734,791.34	17,027,308.66	92.0
210201	Тэтгэврийн даатгал	145,358,300.00	130,641,691.34	14,716,608.66	89.9
210202	Тэтгэмжийн даатгал	17,100,900.00	16,523,200.00	577,700.00	96.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,680,800.00	13,218,800.00	462,000.00	96.6
210204	Ажилгүйдлийн даатгал	3,420,100.00	3,304,700.00	115,400.00	96.6
210205	Эрүүл мэндийн даатгал	34,202,000.00	33,046,400.00	1,155,600.00	96.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	303,745,183.88	303,745,183.88	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	17,853,907.61	17,853,907.61	0.00	100.0
210302	Түлш, халаалт	195,372,585.02	195,372,585.02	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	59,049,391.25	59,049,391.25	0.00	100.0
2105	Нормативт зардал	44,752,300.00	36,331,091.40	8,421,208.60	81.2
210502	Хоол, хүнс	44,752,300.00	36,331,091.40	8,421,208.60	81.2
210604	Урсгал засвар	31,469,300.00	31,469,300.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,534,200.00	15,078,943.27	9,455,256.73	61.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,876,100.00	5,514,700.00	5,361,400.00	50.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,658,100.00	9,564,243.27	4,093,856.73	70.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	156,756,200.00	151,724,240.40	5,031,959.60	96.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,118,300.00	131,086,340.40	5,031,959.60	96.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,637,900.00	20,637,900.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153,213,000.00	125,680,976.20	27,532,023.80	82.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	153,213,000.00	125,680,976.20	27,532,023.80	82.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	135,457,400.00	107,825,376.20	27,632,023.80	79.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,755,600.00	17,855,600.00	-100,000.00	100.6
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,606,863,283.88	2,408,526,427.54	198,336,856.34	92.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,196,293,300.00	2,196,223,300.00	70,000.00	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,196,293,300.00	2,196,223,300.00	70,000.00	100.0
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	303,745,183.88	303,745,183.88	0.00	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	106,824,800.00	13,805,688.00	93,019,112.00	12.9
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,176,100.00	11,275,688.00	-99,588.00	100.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,845,900.00	2,530,000.00	8,315,900.00	23.3
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	84,802,800.00	0.00	84,802,800.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	84,837,860.67	-84,837,860.67	#DIV/0!
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	190,085,605.01	-190,085,605.01	#DIV/0!

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь "Хүүхдийн сэтгэлийг ойлгон дэмждэг, хариуцлагатай мэдлэг чадвар ёс суртахуунаар үлгэрлэсэн хамт олон байна" гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Тус байгууллага нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулах,
- Сурагчдын хөгжил, төлөвшлийг хангах,
- Сургалтын үйл ажиллагаа, багшийн ажлын гүйцэтгэлд суурилан багшийн тасралтгүй хөгжлийг хангах,
- Сургуульд суурилсан менежментийг сайжруулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд шинэчлэн батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд: 1."ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх", 2."Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дээд шатны төсвийн захирагчдаас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 379,678.9 мянган төгрөгөөр буюу 8.72 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	84,837.9	190,085.6	105,247.7
Авлага	975.7		(975.7)
Бараа материал	42,568.5	48,505.1	5,936.6
Үндсэн хөрөнгө	4,225,787.5	4,495,257.8	269,470.3
Нийт хөрөнгө	4,354,169.6	4,733,848.5	379,678.9
Өр төлбөр	19,442.0		(19,442.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,334,727.6	4,733,848.5	399,120.9

Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,354,169.6	4,733,848.5	379,678.9
---------------------------------------	-------------	-------------	-----------

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 190,085.6 мянган төгрөг болж 105,247.7 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 48,501.1 мянган төгрөг болж 5,936.6 мянган төгрөгөөр өссөн нь БШУГ-аас 5,132.5 мянган төгрөгийн ном, 12,549.2 мянган төгрөгийн химийн кабинетын материал, сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 4,900.0 мянган төгрөгийн замын цагдаагийн гэрэл,хуванцар самбар, БШУЯ-наас 13,300.0 мянган төгрөгийн ном тус тус үнэ төлбөргүй авч, төсвийн хөрөнгөөр 211,803.9 мянган төгрөгийн худалдан авалт хийж 222,822.4 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,495,257.8 мянган төгрөг болж 269,470.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 76,596.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, БШУЯ-аас 3780,4 мянган төгрөгийн түрээсийн ном, 213,828.8 мянган төгрөгийн цахим анги болон химийн кабинет, сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар 62,585.9 мянган төгрөгийн гадна фасад, аж ахуй нэгж хувь иргэдээс 2,669.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй авч 89,991.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,903,807.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 228,628.5 мянган төгрөг, нийт 2,132,435.56 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг 183,909.8 мянган төгрөгөөр буюу бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 13,34.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 47,408.6 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 1,237.7 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 116,903.3 мянган төгрөгөөр, Нэг удаагийн шагнал урамшуулал 4,500.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж 1,948,525.8 мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд төсөвт 3 удаа өөрчлөлт орж 11 дүгээр сард цалин, НДШ-ийн зардлыг 434,309.70 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 55,987.8 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 4,055.4 мянган төгрөгөөр, урсгал зардлыг 19,128.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 10,876.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 94,592.6 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 150.7 мянган төгрөгөөр нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 39,236.3 мянган төгрөгөөр, нийт 658,337.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Ингэснээр улсын төсвөөс 2,196,293.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 303,745.2 мянган төгрөгийн санхүүжилт, урьд оны үлдэгдлээс 106,824.8 мянган төгрөг төвлөрүүлэхээр, төсвийг нийт 2,606,863.3 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 2,606,863.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 2,408,526.4 мянган төгрөгийг зарцуулж 198,336.9 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,408,526.4 мянган төгрөг буюу 92.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 159,631.9 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 27,632.0 мянган төгрөгөөр, дотуур байрны зардлыг 11,072.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/		
Д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	5,506.4	5,506.4	-	100.0
		2	80312- Сургалт семинар	2,785.2	2,785.2	-	100.0
		3	81806-Дотуур байр	71,277.5	60,204.6	11,072.9	84.5
		4	81605- Эрүүл мэндийг дэмжих	5,463.3	5,463.3	-	100.0
		5	81801- Үдийн цай хөтөлбөр	135,457.4	107,825.4	27,632.0	79.6
		6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	71,511.4	71,511.4	-	100.0
		7	81823- Боловсролын багшийн сургалт	13,389.9	13,328.2	61.7	99.5
		8	81834- Боловсролын стандарт сургалт	1,673,038.5	1,538,588.8	134,449.7	92.0
		9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	302,631.5	287,752.4	14,879.1	95.1
		11	81848-сурах бичгийн түрээс	10,876.1	5,514.7	5,361.4	50.7
		12	83603- Дээд шатны төсвөөс	3,470.9	3,470.9	-	100.0

	13	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	7,710.0	2,830.0	4,880.0	36.7
	14	Тогтмол зардал	303,745.2	303,745.2	-	100.0
	Нийт		2,606,863.3	2,408,526.4	198,336.9	92.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав. Төлөвлөгөө таарахгүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан боловч бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй тул “Их наран булаг, “Ноцох дөл” ХХК, “Уужим хараа” ХХК-иудтай шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг, чанарын хяналтыг захирал Б.Жаргалсайхан, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Пийк Ом Аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,994,083.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 19,940.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тасгаж журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд тус сургуулийн үйл ажиллагаанд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК-ийн 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 215 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийг зүй зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн 975.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй 41,905.9 мянган төгрөгийн, шилэн дансны цахим хуудсанд 10 мэдээллийг хугацаа хоцроосон зөрчлийг дахин гаргахгүй ажиллах зөвлөмж өгсөн байна.

Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	41,905.9	2	41,905.9	100.0
Албан шаардлага	1	975.7	1	975.7	100.0
Нийт дүн	3	42,881.6	3	42,881.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд **“Зөрчилгүй”, “Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан”** гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу дараах албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал тус бүр хоёр сарын үндсэн цалинтай тэнцэх буюу **1,564.4** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Үүнд:

- Нягтлан бодогч Ч.Цэндмаа 1,750.6 мянган төгрөг,
- Нярав С.Отгонцацрал 1,378.2 мянган төгрөг .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа илрээгүй байна.

Аудитаар нийт **45,119.1** мянган төгрөгийн зөрчил илэрч **19,024.5** мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, **26,094.6** мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд БЕГ-аас байгууллага, багш нарын ажлын үр дүнг үнэлсэн үнэлгээний дагуу тухай бүр гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгосон боловч сургуулийн захирлын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Б/88 дугаар тушаалаар 42 багшид тус бүр үндсэн цалингийн 10.0-100.0 хувиар тооцон, нийт **19,024.5** мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:”, 15.1.3 дахь “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт хүргүүлэх.

5.2 Албан шаардлага

1. Сургуулийн захирлын 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 85, 12 дугаар сарын 21-ний өдрийн Б/88 дугаар тушаалаар 38 багш, ажилтныг эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж, манлайлсан гэх үндэслэлээр шагнах шийдвэр гаргаж, цалингийн батлагдсан төсвөөс шагналын зардалд нийт **26,094.6** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлж байх албан шаардлага хүргүүлэх,

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урамшуулал давхардуулан олгосон	1	19,024.5	1	19,024.5								
Цалингийн зардлаас шагналын зардалд зориулалт бусаар зарцуулсан	1	26,094.6			1	26,094.6						
Дүн	2	45,119.1	1	19,024.5	1	26,094.6						